



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/395

Булган сум

Хагас жилийн мал тооллого
явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "в", 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хагас жилийн мал тооллогыг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. Тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулан явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


3. Мөрдөгдөж буй заавар журмын дагуу мэдээлэл цуглуулалтын чанар бодит байдалд анхаарч, тооллогын ажилд томилогдсон албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч болзошгүй алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг тооллогын ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д, хагас жилийн малын түүвэр судалгааны аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явц, сан бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтсийн дарга (М.Мөнхбат)-д тус тус даалгасугай.

4. Хагас жилийн мал тооллогын дүнг 2026 оны 6 дугаар сарын 19-ний дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ЦУРЭВ-ОЧИР





2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН МАЛ ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Ажлын хэсгийн орлогч дарга: М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
Гишүүд: Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
Н.Булганбаяр (Статистикийн хэлтсийн мэргэжилтэн)
Д.Баттулга ("МИГ" даатгалын захирал)
Нарийн бичгийн дарга: Ц.Батчимэг (Статистикийн хэлтсийн Хөдөө аж ахуй хариуцсан)

--o00o--